



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 07 дугаар сарын 21

№ 02/17

Улаанбаатар хот

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
ТАНАА

Комисс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 25 дугаар зүйлийн 25.1.6, 25.1.7 дахь заалтыг удирдлага болгон иргэн дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой ач хүү Б.Дөлгөөний хүүхдийн эрх зөрчигдөж байгаа талаар гаргасан гомдлын мөрөөр 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хяналт шалгалтыг хийсэн.

Хяналт шалгалтыг тус хэлтсийн дарга, ажилтан, албан хаагчдаас тайлбар, мэдээлэл, тодруулга авах, баримт бичигтэй газар дээр нь танилцах, зарим баримт бичигт дүн шинжилгээ хийх зэрэг аргачлалаар явуулсан бөгөөд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Цугларсан баримт, материалыг судлахад Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хорооны хамтарсан баг 2020 оны 5 дугаар сар 18-ны өдөр, 5 дугаар сарын 26-ны өдөр "Иргэн нь өөрийн ач хүү асран хамгаалагч болох хүсэлтэй тухай" асуудлыг тус тус хэлэлцсэн, мөн тус дүүргийн 35 дугаар хорооны хамтарсан багийн 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар "Иргэн нь өөрийн ач хүү асран хамгаалагч болох хүсэлтэй тухай" асуудал, мөн оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар хүүхдийн төв сувилалд жингийн бага зэргийн дутагдалтай гэсэн оноштой сувилуулж байгаад гэр бүлд нь нэгтгэх тухай" асуудлыг тус тус хэлэлцсэн байна. Мөн иргэн ач хүү хувийн хэрэгт үзлэг хийхэд нөхцөл байдлын үнэлгээ болон хурлын тэмдэглэлийг албажуулаагүй урагдаж муудсан, нэр хаяггүй хавтаст огноо дараалал эмх цэгцийг алдагдуулсан байдалтай хавсаргасан байсан.

Түүнчлэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, хамтарсан багийн үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээ болон бусад баримт материал байхгүйн зэрэгцээ 2 жилийн хугацаанд аюулын зэргийн үнэлгээг нэг удаа хийсэн байна. 2020-2022 онуудад хүүхдийн эрхийн асуудлаар удаа дараа гомдол гаргаж шүүх эмнэлгийн дүгнэлт хүргүүлсэн байх бөгөөд эдгээрийг хамтарсан баг хэлэлцээгүй, холбоотой нөхцөл байдлын үнэлгээ болон илтгэх хуудсанд гарын үсэг зурагдаагүй, үнэн эсэх нь эргэлзээтэй байсан. Энэ талаар тус хэлтсийн дарга ач хүү талаар олон байгууллагаас холбогдох баримт ирүүл, мөн Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын газарт эх хувийг нь авсан. Хүүхдийн улсын байцаагч бол хүүхдийн мөнгөний асуудлыг хариуцаж байгаа" гэсэн тайлбарыг өгсөн. Тус хэлтсийн ахлах

150060046

мэргэжилтэн "манай хэлтсийн зүгээс хангалттай үйлчилгээг энэ үзүүлсэн, харин хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн баримт материалууд Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт эх хувиараа байгаа. Ер нь анхан шатны нэгж дээр ажлын ачаалал ихтэй, хүний нөөцийн дутагдалтай гэх хүндрэлтэй асуудал цөөнгүй байдаг" гэх тайлбарыг өгсөн. Мөн уг асуудалтай холбогдуулан бусад албан хаагчдаас хүүхэд хамгааллын ямар үйлчилгээг үзүүлсэн, хамтарсан баг хэрхэн ажилласан талаар тодруулахад тодорхой өгөх тайлбар байхгүй, "35 дугаар хороон дээр байгаа, нэг бол 2 дугаар хороон дээр байгаа, дуудсан байгаа эсвэл Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт байгаа, О.Шинэбаяр өөрөө л шүүх эмнэлэгт аваачиж дүгнэлт гаргуулдаг" гэх мэт тайлбар хийж яг ямар тусламж, үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлсэн нь тодорхойгүй байна.

2. Иргэн О.Шинэбаяр Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт удаа дараа гомдол гаргахад өөрт нь Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргаар хянуулсан хүүхдийн эрхийн асуудал хариуцсан мэргэжилтний бичсэн илтгэх хуудсаар хариу өгсөн байх бөгөөд асуудлыг хэрхэн шийдсэн талаар тусгаагүй, байгууллагын хэвлэмэл хуудас дээр албажуулж хариу өгөөгүй байна.

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн тус хэлтсийн удирдлага, ажилтан, албан хаагчид нь Монгол Улсын нэгдэн орсон хүүхдийн эрхийн олон улсын гэрээ, конвенц, Хүүхдийн эрх, Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээлгэсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ аваагүй, хүүхэд хамгааллын үйлчилгээнд зохих ёсны хяналт тавиагүй, ажилдаа мэргэжлийн бус, хайхрамжгүй хандсан, хүүхдийн язгуур эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлээгүй улмаар хүүхдийн эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн гэж дүгнэж байна.

Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу дараах шаардлагыг хүргүүлж байна. Үүнд:


1. Холбогдох хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг зохих ёсоор үзүүлэх, Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн удирдлага ажилтан, албан хаагчдад мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, мэргэжлийн бус үйл ажиллагаа явуулж алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох, цаашид энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч дорвитой арга хэмжээ авах;
3. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл бүрд Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн холбогдох заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны А/1201, А/178 дугаар хамтарсан тушаалаар баталсан нөхцөл байдлын үнэлгээ хийх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаар журамд тус тус заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хуульд заасан үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах;
4. Төрийн албан хаагчийг чадавхжуулж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргээ чанд сахиж, энэ талаар харьяа салбар хэлтэс, албадуудын албан хаагч, ажилтнуудыг соён гэгээрүүлэх, хүний

эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг идэвхтэй, үр дүнтэй явуулах;

5. Цаашид хүүхдийн язгуур эрх, дээд ашиг сонирхлыг хангаж, хамгаалахад Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдлөг болгон ажиллах;

Шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

ДАРГА



Ж.ХУНАН